

## **Харилцан Зөвшөөрөх тухай Тодорхойлолт**

Харилцан зөвшөөрөх гэдэг нь бэлгийн харилцаанд оролцогч талууд үйлдлээ ухамсарлаж, сайн дураар, харилцан зөвшилцсөн үйл ажиллагааг хэлнэ. Зөвшөөрөл нь сексийн харилцаанд оролцох сонирхолтой байгааг тодорхой утга бүхий үгээр эсвэл үйлдлээр илэрхийлж болдог. Дуугүй байх, эсэргүүцэл үзүүлэхгүй байх үйлдэл нь зөвшөөрлийн хэлбэрт тооцогдохгүй. Зөвшөөрөл өгөх тухай тодорхойлолт нь тухайн үйл ажиллагаанд оролцогчийн хүйс, бэлгийн чиг хандлага, хүйсийн адил тал зэргээс хамаарч хувирахгүй.

Гуравдагч этгээдтэй урьдчилан амаар тохиролцсон секс үйлдэл эсвэл бэлгийн харилцаа нь бэлгийн харилцааны зөвшөөрөл өгсөн гэх үндэслэл болохгүй.

Тухайн үйлдлийг санаачилж буй хүн архи/мансуурах бодисын нөлөөнд байгаа эсэхээс үл хамаарч зөвшөөрөл өгсөн/авсан байх шаардлагатай.

Эхлүүлсэн зөвшөөрлийг ямар ч үед цуцалж болно.

Хүн бэлгийн харилцаанд орох чадвараа бүрэн алдсан үед зөвшөөрөл өгөх боломжгүй. Энэ нь тухайн хүн бэлгийн харилцаанд оролцох гэж буйгаа өөрөө мэдэх чадваргүй байгааг хэлнэ. Чадвар алдах гэдэгт тухайн хүн ухаангүй байх, унтаа хэлбэрт байх, бусдын нөлөөнд орсон байх зэрэг ойлголт багтана. Согтуурлын зэргээс хамаарч архи юм уу мансуурах болон бусад бодисын нөлөөнд байгаа хүн чадвар алдсан байж болох бөгөөд түүнчлэн зөвшөөрөл өгөх чадваргүй байж болно.

Албадлага, айлган сүрдүүлэлт, заналхийлэл болон хүч хэрэглэсэн үед өгсөн зөвшөөрлийг зөвшөөрсөн гэж үзэхгүй.

Хэрэв зөвшөөрлөөс буцсан, татгалзсан нөхцөлд сексийн үйл ажиллагааг мөн зогсоох ёстой.

## **Мансууруулах бодис, Архи Хэрэглэсэн хариуцлагаас чөлөөлөх тохиолдол**

Тус Rockland Community College -ийн оюутан бүрийн эрүүл мэнд, аюулгүй байдал хамгийн чухал зүйл юм. RCC -ийн зүгээс ахуйн хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүчирхийлэл болон бусад төрлийн зөрчил гарах үед байлцсан, согтууруулах ундаа, мансууруулах бодис ашиглаж байсан (сайн дураар эсвэл албадлагаар) оюутнууд өөрсдийн гаргасан зөрчил илчлэгдэхээс эмээж тухайн хэргийг мэдээлэхээс зайлсхийх боломжтой гэж үздэг. RCC нь ахуйн хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн хамтрагчийг дарамтлах, тагнан мөрдөх болон бусад төрлийн зөрчлийг сургуулийн захиргаанд мэдээлж байхыг оюутнуудад хатуу анхааруулдаг. Сайн үйл хийж буй, сайн санаагаар ахуйн хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн хамтрагчийг дарамтлах, тагнан мөрдөх болон бусад төрлийн зөрчлүүдийг RCC -н захиргаанд юм уу хууль сахиулах байгууллагад мэдээлсэн хүн нь хэрэв тухайн ахуйн хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн хамтрагчийг дарамтлах, тагнан мөрдөх болон бусад төрлийн зөрчлийн ойролцоо байсан бол RCC's -н архи тамхи, мансууруулах бодисын эсрэг журмаар шийтгэл хүлээхгүй.

## **Оюутнуудын эрхийн тухай**

Бүх оюутнууд дараах эрхийг эдэлнэ:

Орон нутгийн хууль сахиулах байгууллага/ юм уу мужийн цагдаад дуудлага өгөх;

Ахуйн хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн хамтрагчийн дарамт, тагнан мөрдөх болон бусад төрлийн зөрчлийг илчлэх;

Гэмт хэрэг, зөрчлийг илчлэх эсэх тухай, шүүхийн юм уу хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд тус сургуулийн шахалтаас ангид оролцох эсэх шийдвэр гаргах;

Шударга, эрх тэгш, хангалттай мэдээллээр хангах, утга төгөлдөр агуулга бүхий арга хэмжээнд оролцох;

Нэр төртэй байх, сургуулийн удирдлагын зүгээс шударга эн тэнцүү үйлчилгээ авах, боломжтой бол эрүүл мэнд, зөвлөх үйлчилгээ авах;

Гэмт хэрэг, зөрчил гарах үед тухайн хэргийг мэдээлсэн хүн буруутай байсан гэх, эсвэл тухайн хэрэг зөрчил гарахаас сэргийлж өөр үйлдэл хийж болох байсан гэх үндэслэлээр буруутгагдахгүй байх;

Хэрэг явдлыг хамаарах эрх бүхий байгууллагуудад тодорхойлж мэдүүлэх бөгөөд тухайн хэрэг явдлын талаарх тодорхойлолтыг дахин давтах үүрэг хүлээхгүй байх.

Сургууль, оюутнууд, сэжигтэн/ эсвэл дуудлагаар ирсэн ажилтан, мөн/эсвэл тэдгээрийн найз, гэр бүл болон сургуулийн харьяаны хүмүүстэй харилцаа үүсэхээс хамгаалуулах;

Дор хаяж нэг удаа давж заалдах шийдвэр гаргах эрхтэй байх;

Хувь хүн, сэжигтэн, хариуцагчийн тухай шүүхийн шатанд тухайлбал бүх хурал уулзалт, шүүх хурал, сахилгын хуралд мэдүүлэг өгөх үед зөвлөх хүнийг өөрөө сонгон авч туслалцаа авах;

Мөрдөн байцаах, эрүүгийн шүүх, мөн шүүхийн болон сургуулийн сахилгын үйл ажиллагаанаас үл хамаарч иргэний болон шашин шүтэх эрхээ эдлэх.

Эдгээр эрх нь арьс, өнгө, үндэс гарал, шашин шүтлэг, итгэл үнэмшил, нас, биеийн чадвар, хүйсийн хандлага сонирхол, бэлгийн чиг хандлага, гэр бүлийн байдал, жирэмсэн эсэх, генийн урьдчилсан өөрчлөлт, цэргийн алба хаасан/хааж буй эсэх, ахуйн хүчирхийллийн хохирогч эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх, гэмт хэрэг зөрчил сургуулийн хүрээнд/ эсвэл гадна болсон эсэх гадаадад сурч байх хугацаанд үйлдэгдсэн эсэхээс үл хамааран хүн бүрт тэгш үйлчилнэ.

Та Их Сургуулийн Цагдаа юм уу кампусын хамгаалалтын алба, орон нутгийн хууль сахиулах/цагдаагийн албанд мэдээлэх, эс мэдээлэх; өөрийн сургуульд хэргийг мэдээлэх, хэрэг зөрчлийг мэдээлсний улмаас бусдын нөлөөнд орохоос хамгаалуулах, болон сургуулиас туслалцаа мэдээлэл авах эрхээр хангагдана.